



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 0402

Хэрлэн сум

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын
улсын тооллого зохион байгуулах,
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.4, 16.1.5 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-ын 2.2 дахь хэсэг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газрын даргын А/14 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээний нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 2022 оны 8 дугаар сарын 01-ээс 2022 оны 11 дүгээр сарын 15-ыг хуртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Зулбаатар

Соёл, урлагийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Л.Бүрэнтөгс

Соёл, урлагийн газрын
Соёлын өвийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Д.Баатарцот

Соёл, урлагийн газрын
Соёлын хэлтсийн дарга

Д.Отгонцолмон

Мэргэжлийн хяналтын
газрын боловсрол, соёлын
хяналтын улсын байцаагч

Р.Энхбаяр

Музейн Соёлын биет бус өв,
Түүх соёлын үл хөдлөх дурсгал

хариуцсан бүртгэл
мэдээллийн санч

Б.Төгсжаргал

Музейн түүх, соёлын үл
хөдлөх дурсгал хариуцсан
эрдэм шинжилгээний
ажилтан

Н.Наранбаяр

Хэнтий аймгийн газрын
харилцаа, барилга хот
байгуулалтын газрын геодез
зурагзүй хариуцсан
мэргэжилтэн

3. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг түүх,
соёлын үл хөдлөх дурсгалын тооллого зохион байгуулахад сумдын засаг дарга нар
үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлэн тооллогын ажлыг чанартай гүйцэтгэхийг
үүрэг болгосугай.

4. Тооллогын ажлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион
байгуулж, нэгдсэн дүн, цаашид авах арга хэмжээний саналыг аймгийн удирдлагын
зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын кэсэг дарга (Т.Зулбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

